



ᠪᠤᠯᠠᠭᠠᠨ ᠠᠶᠢᠮᠭᠢᠨ
ᠨᠢᠶᠢᠭᠦᠮ ᠡᠳᠢᠶᠢᠨ ᠵᠠᠰᠭᠢᠨ
ᠲᠤ ᠰᠠᠷᠢᠨ ᠲᠠᠨᠢᠯᠴᠤᠭᠤᠯᠠᠭ᠎ᠠ

Булган аймгийн НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙН 2 сарын танилцуулга

СТАТИСТИК МЭДЭЭЛЛИЙГ ХЭРХЭН АВАХ ВЭ?

www.1212.mn
СТАТИСТИКИЙН МЭДЭЭЛЛИЙН
НЭГДСЭН САН

www.nso.mn сайтын
Хэрэглэгчийн бүртгэлд
бүртгүүлснээр цахим
хаягаар тогтмол
авч болно.

Monstat ezStat
апликайшн

1900-1212
Лавлах утас

@statistic_mn

Статистик
мэдээлэл

Үндэсний Статистикийн
Хорооны
НОМЫН САН

Онлайн лавлах
мессенжер
8:30-17:30

ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭГ

ХҮНД СУРТАЛ
АВИЛГА

ҮГҮЙ НЭЭЛТТЭЙ
ХҮРГЭНЭ

ГАРЧИГ

Аргачлал тайлбар	4
Товч танилцуулга	8
I.1 Хүн ам	17
I.2 Хөдөлмөр	18
I.3 Нийгмийн халамж	19
I.3 Нийгмийн даатгал	20
I.4 Эрүүл мэнд	20
I.5 Гэмт хэрэг	21
II.1 Үнэ	28
II.2 Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний үнэ	30
II.3 Малын үнэ	32
II.4 Аж үйлдвэр	33
II.5 Мал аж ахуй	34

Аргачлалын тайлбар

Хөдөлмөр

Бүртгэлтэй ажилгүй иргэдэд Монгол Улсын хуулиар зөвшөөрөгдсөн хөдөлмөрлөх насны, хөдөлмөр эрхлэх чадвартай, цалин хөлстэй ажил болон хувиараа хөдөлмөр эрхлэгдэггүй, тухайн үед ажиллахад бэлэн, цалин хөлстэй ажил идэвхитэй хайж байгаа хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэс, хөдөлмөрийн төв бирж, хөдөлмөрийн хувийн биржид бүртгүүлсэн ажилгүй иргэдийг хамруулна.

Нийгмийн даатгал, халамж

Нийгмийн даатгал нь иргэн болон төр, аж ахуйн нэгж байгууллагаас зохих журмын дагуу шимтгэл төлж, нийгмийн даатгалын сан бүрдүүлэх, даатгуулах, өндөр наслах, хөдөлмөрийн чадвараа алдах, өвчлөх, ажилгүй болоход өөрт нь, тэрчлэн даатгуулагч нас барахад түүний асрамжид байсан хүмүүст хууль тогтоомжид заасан тэтгэвэр, тэтгэмж, төлбөр өгөх агуулга бүхий нийгэм эдийн засгийн арга хэмжээ юм. Тэтгэврийн, тэтгэмжийн, эрүүл мэндийн, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалан өвчний, ажилгүйдлийн даатгал гэсэн төрлөөс нийгмийн даатгал бүрдэнэ. Нийгмийн даатгалын сан нь ажил олгогч, даатгуулагчийн хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогоос тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, үйлчилгээнд зарцуулах болон нийгмийн даатгалын үйл ажиллагааны зардлыг нөхөх зорилгоор төлсөн шимтгэлийн орлого, бусад эх үүсвэрээс бүрдэнэ. Нийгмийн даатгалын тухай хууль болон гэрээний үндсэн дээр нийгмийн даатгалын санд нийгмийн даатгалын шимтгэл төлж даатгуулсан, нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж, төлбөр авах эрх бүхий этгээдийг даатгуулагчаар тооцно. Тэтгэвэр нь даатгуулагчийг өндөр наслахад насан туршид нь, хөгжлийн бэрхшээлтэй болоход хөдөлмөрийн чадвар нь сэргээгдэх хүртэл, нас барахад нь түүний гэр бүлийн хөдөлмөрийн чадваргүй гишүүд (хүүхэд 16 нас, сургуульд суралцаж байгаа бол 19 нас хүртэл)-ийн нийгмийн баталгааг хангах зорилгоор нийгмийн

даатгалын сангаас олгох мөнгөн хөрөнгө байна.

Тэтгэмж нь хөдөлмөрийн чадвараа түр алдах, жирэмслэх, амаржих, нас барах тохиолдолд даатгуулагчид нийгмийн даатгалын сангаас нэг удаа олгох мөнгөн хөрөнгө байна. Нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа шаардлагатай хүнд хуульд заасан тэтгэвэр, нөхцөлт мөнгөн тэтгэмж олгох, олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн болон төрөлжсөн асрамжийн үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагааг нийгмийн халамж гэнэ

Эрүүл мэнд

Жирэмслэлтийн хугацаанаас хамаарахгүйгээр ердийн төрөлтөөр эсвэл мэс ажилбараар ургийг умайнаас гарган авсны дараа нярай амьсгалж байсан эсвэл амьдын бусад ямар нэгэн шинж тэмдэг, өөрөөр хэлбэл, зүрхний цохилт, хүйний судасны лугшилт, булчингийн тодорхой хөдөлгөөн илэрч байвал хүй эсвэл эхэсийг салгасан эсэхийг харгалзахгүйгээр амьд төрөлтөд тооцно.

Амьд төрсөн 1000 хүүхдэд ногдох нялхсын эндэгдлийг тодорхойлохдоо тухайн хугацаанд 1 хүртэлх насандаа эндсэн хүүхдийн тоог амьд төрсөн хүүхдийн тоонд харьцуулна.

Амьд төрсөн 1000 хүүхдэд ногдох хүүхдийн эндэгдлийг тооцохдоо тухайн хугацаанд 5 хүртэлх насандаа эндсэн хүүхдийн тоог амьд төрсөн хүүхдийн тоонд хуваана. Эндсэн эхийн тоонд жирэмсний хугацаанд болон төрөх үедээ эсвэл төрснөөс хойш 42 хоногийн дотор жирэмслэлтийн байрлал, үргэлжилсэн хугацаанаас үл хамааран жирэмслэлт, төрөлт болон түүнийг удирдахтай холбоо бүхий шалтгаанаар эндсэн эхийг хамааруулна.

Халдварт өвчний өвчлөлийн 10000 хүнд ногдох түвшинг тооцохдоо тайлант хугацаанд амбулаторийн үзлэгээр шинээр бүртгэгдсэн нийт халдварт өвчний тохиодлын тоог тухайн хугацааны хүн амын тоонд харьцуулна.

Аюулт үзэгдэл, осол

Гамшиг гэж аюулт үзэгдэл, техникийн холбогдолтой осол, алан хядах ажиллагаа, дэлбэрэлтийн улмаас олон хүний эрүүл мэнд, амь нас хохирох, мал амьтан олноор хорогдох, эд хөрөнгө, хүрээлэн байгаа орчинд улс, орон нутгийн дотоод нөөц боломжоос давсан хохирол учрахыг хэлнэ.

Аюулт үзэгдэл гэж хүчтэй цасан болон шроон шуурга, ган, зуд, үер, газар хөдлөлт, цөлжилт болох, гал түймэр, хүн, мал, амьтны болон ургамлын гоц халдварт өвчин гарах, хортон мэрэгчид тархах зэргийг хамруулан ойлгоно. Техникийн холбогдолтой осол гэж үйлдвэрлэл, технологийн горим зөрчигдсөнөөс тоног төхөөрөмж, барилга, байгууламж, шугам, сүлжээ эвдрэх, тээврийн хэрэгсэл осолдох, сүйрэх, цацраг идэвхт болон химийн хорт бодис алдагдах зэргийг хамруулан ойлгоно.

Гэмт хэрэг

Эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр Монгол Улсын Эрүүгийн хуульд заасан, нийгэмд аюултай, гэм буруутай үйлдэл, эс үйлдэхүйг гэмт хэрэг гэнэ. Гэмт хэргийн нийгмийн шинж чанар, аюулын хэр хэмжээ, оногдуулж болох ялын хүнд хөнгөнийг харгалзан гэмт хэргийг хөнгөн, хүндэвтэр, хүнд, онц хүнд гэж ангилна. Гэмт хэргийн тоог Монгол Улсын Эрүүгийн хуульд заасны дагуу гэмт хэргийн төрлөөр нэгтгэн гаргаж байна. Тухайлбал:

- Хүний ам бие, эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг
- Хүүхэд гэр бүл, нийгмийн эсрэг гэмт хэрэг
- Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг
- Үндэсний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг
- Нийгмийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг
- Хүн амын эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг
- Тээврийн хэрэгслийн хөдөлгөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг
- Шүүн таслах ажиллагааны эсрэг гэмт хэрэг
- Байгаль хамгаалах журмын эсрэг гэмт хэрэг
- Бусад гэмт хэрэг

18 ба түүнээс дээш насны 10000 хүнд ногдох бүртгэгдсэн гэмт хэргийн тоог тодорхойлохдоо нийт бүртгэгдсэн гэмт хэргийн

тоог 18 ба түүнээс дээш насны хүн амын дундаж тоонд харьцуулна.

Дор дурьдсан этгээдэд хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч эрүүгийн хэрэг үүсгэж, үндэслэл бүхий тогтоол гаргасан бол сэжигтнээр тооцно. Үүнд:

-Уг этгээдийг гэмт хэрэг үйлдэж байх үед буюу үйлдэл дор нь барьсан

-Гэмт хэрэг үйлдсэн этгээдийг хохирогч буюу харсан хүн шууд заасан

-Уг этгээдийн бие, хувцас, эд зүйл, орон байранд гэмт хэргийн ул мөр тодорхой илэрч олдсон

-Уг этгээд хэргээ илчлэн ирсэн

-Гэмт хэрэгт сэрдэгдэх үндэслэл бүхий бусад баримт байгаа бол

Хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч тогтоол үйлдэж, ял сонсгосон этгээдийг яллагдагчаар тооцно.

Төрийн санхүү

Орон нутгийн төсвийн суурь орлого гэж тухайн шатны төсөвт орох татварыг доод хувь хэмжээгээр тооцсон орлого болон татварын бус орлогын нийлбэрийг хэлнэ. Орон нутгийн суурь зарлага гэж сум, аймаг, нийслэлийн удирдлагыг хэрэгжүүлэх чиг үүрэгтэй холбогдох урсгал болон хөрөнгийн зарлага, нийгмийн асрамж, халамжийн үйлчилгээ, байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх зардлыг хэлнэ.

Төсвийн тэнцэл гэж тухайн төсвийн жил, улирлын нийт орлого, зарлагын зөрүүг хэлнэ. Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас батлан аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга бүрдүүлж зарцуулах төсөв нь орон нутгийн төсөв байна.

Татварын орлогод орлогын албан татвар, нийгмийн даатгалын шимтгэл, хураамж, өмчийн татвар, дотоодын бараа, үйлчилгээний татвар, гадаад худалдааны татварын орлого болон бусад татвар орно.

Төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжийн төрийн өмчид ногдох хувьцааны ногдол ашиг, хүү, торгуулийн орлого, түрээсийн орлого, төсөвт газрын өөрийн орлого болон

татварын бус бусад орлогоос татварын бус орлого бүрдэнэ.

Төсвийн зарлагыг урсгал зардал, хөрөнгийн зардал, цэвэр зээл гэж ангилна. Бараа, үйлчилгээний зардал, зээлийн үйлчилгээний төлбөр, татаас ба урсгал шилжүүлгээс урсгал зардал бүрдэнэ.

Үнэ

$$I_p^L = \frac{\sum_{i=1}^n p_{it} * q_{io}}{\sum_{i=1}^n p_{io} * q_{io}}$$

I_p^L - t тайлант үеийн Ласпейресийн үнийн индекс

t - тайлан үе

o - суурь үе

p_{it} - i барааны тайлант үеийн үнэ,

p_{io} - i барааны суурь үеийн үнэ,

q_{io} - i барааны суурь үеийн худалдан авсан тоо, хэмжээ,

\sum - нийлбэрийн тэмдэг

Хэрэглээний үнийн индекс (ХҮИ) нь хэрэглэгчдийн худалдаж авсан бараа, үйлчилгээний нэр төрөл, чанар өөрчлөлтгүй тогтвортой байхад үнэ дунджаар хэрхэн өөрчлөгдөж буйг хэмжих үзүүлэлт бөгөөд нийт өрхөөр тооцсон үнийн өөрчлөлтийг харуулна. ХҮИ-ийн тооцоонд хэрэглээний сагс, хэрэглээний жин гэсэн хоёр үзүүлэлтийг ашиглана. Хэрэглээний сагс нь дундаж зарлагатай өрхийн хэрэглээг төлөөлөх чадвартай, хэрэглээний үнийн индекс тооцох зорилгоор бүрдүүлсэн хүн амын өргөн хэрэглээний бараа, үйлчилгээний үнийн өөрчлөлтийг тооцоход бараа, үйлчилгээний тоо хэмжээ, төрөл, чанар зэргийг тогтмолоор авч үздэг. Хэрэглээний бараа үйлчилгээний жин гэж өрхийн худалдаж авсан бараа, үйлчилгээний нийт зардалд тухайн бараа,

үйлчилгээний зардлын эзлэх хувийн жин юм. ХҮИ-ийн тооцоонд Ласпейресийн үнийн индексийн томъёог ашиглаж болно.

Аж үйлдвэр

Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл нь аж ахуйн нэгжүүдийн тайлант хугацаанд зах зээлд болон өөрийн эцсийн хэрэглээнд зориулж үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээс бүрдэнэ.

Аж үйлдвэрийн салбарын борлуулсан бүтээгдэхүүн нь аж ахуйн нэгжүүдийнтайлант хугацаанд худалдсан буюу гадагш гүйцэтгэсэн ажил, үйлчилгээний хэмжээ юм.

Аж ахуйн нэгжүүдийг эдийн засгийн үйл ажиллагаагаар нь ангилахдаа НҮБаас гишүүн орнууддаа мөрдөхийг зөвлөмж болгосон эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны олон улсын стандарт ангилалд үндэслэсэн үндэсний ангиллыг мөрдөж байна.

Ерөнхий тэмдэглэл

I.Саруудыг ром тоогоор тэмдэглэв (I,II,III,IV,V....гэх мэт)

Тухайн сарыг оруулсан жилийн эхнээс өсөн нэмэгдэх дүнг харуулахдаа I-IV, I-X зэргээр илэрхийлэв.

II. Дараах тэмдэглэлийг ашиглав:

... мэдээлэл байхгүй

0.0 маш бага тоо

- гүйцэтгэл байхгүй

III. Орон дэвшүүлэлтээс хамаарч зарим үзүүлэлтийн нийлбэр нь дүнтэйгээ, бүтцийг хувиар илэрхийлэхэд 100 хувиас бага зэрэг зөрүүтэй байж болно.

I. Нийгмийн үзүүлэлт




I.1 Хүн ам

2021 оны 2-р сарын байдлаар иргэний бүртгэлд шинээр төрсөн 194 хүүхэд, нас барсан 70 хүний бүртгэлийг бүртгэсэн нь өмнөх оны мөн үеийнхээс шинэ төрсөн хүүхэд 19 буюу 9.8 хувиар, нас баралт 16 буюу 22.9 хувиар тус тус өсчээ.

Зураг I.1.1


Бүртгэгдсэн төрөлт, нас баралт



2 сарын байдлаар 162 хүн шилжиж ирсэн нь өмнөх оны мөн үеийнхээс 119 буюу 42.3 хувиар буурчээ.

Зураг I.1.2

Бүртгэгдсэн шилжих хөдөлгөөн



I.2 Бүртгэлтэй, ажилгүй иргэн

Аймгийн хөдөлмөрийн хэлтэст бүртгэлтэй ажилгүй иргэн 433 болсны 185 нь эмэгтэй байна. Бүртгэлтэй ажилгүй иргэдийн 15.2 хувийг бакалаврын болон дипломын боловсролтой, 8.8 хувийг тусгай мэргэжлийн дунд, 3.9 хувийг техникийн болон мэргэжлийн, 62.1 хувийг бүрэн дунд боловсролтой, 5.5 хувийг суурь боловсролтой, 3.2 хувийг бага боловсролтой, 0.9 хувийг боловсролгүй иргэд эзэлж байна.

Зураг I.2.1


Хөдөлмөрийн хэлтэст шинээр бүртгүүлсэн, ажил хайгч иргэд



Аймгийн хэмжээнд бүртгэлтэй ажилгүй иргэдийн 15.2 хувийг 15-24 насны, 30.7 хувийг 25-34 насны, 27.7 хувийг 35-44 насны, 21.7 хувийг 45-54 насны, 3.9 хувийг 55-59 насны, 0.7 хувийг 60-аас дээш, 2.3 хувийг хөгжшлийн бэрхшээлтэй иргэд эзэлж байна.

Зураг I.2.2

Бүртгэлтэй ажилгүй иргэд боловсролын түвшингээр



I.3.1 Нийгмийн халамж

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын мэдээллээр нийгмийн халамжийн сангаас 2021 оны 2-р сарын байдлаар 7256 хүн 982.2 сая төгрөгийн тэтгэвэр, тэтгэмж олгосон нь өмнөх оны мөн үеийнхээс нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж авагчид 293.7 сая.төг буюу 42.7 хувиар өсч, харин нийгмийн халамжийн тэтгэвэрт 1037 хүн хамрагдаж 586.8 сая.төг олгосон нь өмнөх оны мөн үеийнхээс 222.1 сая.төг буюу 60.9 хувиар өссөн байна. Нийгмийн халамжийн үйлчилгээ, хөнгөлөлтөд 2021 оны 2-р сарын байдлаар 234 хүн хамрагдсаны 80.8 хувь ахмад настан, 17.1 хувь нь хөгжлийн бэрхшээлтэй иргэд, 2.1 хувь нь олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ байна. Хүнс тэжээл хөтөлбөрт хамрагдсан 4545 иргэн 109.9 сая төгрөг олгосон байна.



I.3.Нийгмийн даатгал, халамж Нийгмийн даатгал

Нийгмийн даатгалын сангийн орлого 6967.5 сая төгрөг болж өмнөх оны мөн үеэс 4669.1 (67%) сая.төгрөгөөр, зарлага 8588.3 сая төг болж өмнөх оны мөн үеэс 1235.0(16.8%) сая төгрөгөөр тус тус өссөн байна.

Тэтгэврийн даатгалын сангийн орлого өмнөх оны мөн үеэс 4658.0(3.4 дахин) сая төгрөгөөр, тэтгэмжийн даатгалын сангийн орлого өмнөх оны мөн үеэс 20.3(10.3%) сая төгрөгөөр, ажилгүйдлийн даатгалын сангийн орлого 55.3(2.3 дахин) сая төгрөгөөр тус тус өсч, ҮОМШӨ-ний даатгалын сангийн орлого 64.6 сая төгрөгөөр буурсан байна.

Нийгмийн даатгалын сангийн зарлага 8588.3 сая төгрөг болж өмнөх оны мөн үеэс ҮОМШӨ-ний даатгалын сангийн зарлага 4.8(9.8%) сая төгрөгөөр, тэтгэврийн даатгалын сангийн зарлага 1159.6(16.5%) сая төгрөгөөр өссөн, ажилгүйдлийн даатгалын сангийн зарлага 74.5(2.4 дахин) сая төгрөгөөр өссөн байна. Харин тэтгэмжийн даатгалын сангийн зарлага 3.9(1.7%) сая төгрөгөөр буурсан байна.




I.4 Эрүүл мэнд

Аймгийн хэмжээнд 2021 оны 2-р сарын байдлаар 163 эх амаржиж, амьд төрсөн хүүхдийн тоо 164 болж, өмнөх оны мөн үеийнхээс амаржсан эх 44 буюу 26.9 хувиар, амьд төрсөн хүүхдийн тоо 43 буюу 26.2 хувиар тус тус өссөн байна.

Зураг I.4.1

Амаржсан эх, амьд төрсөн хүүхэд



2021 оны 2-р сарын байдлаар нялхасын эндэгдэлгүй байна.

Зураг I.4.2




Халдварт өвчнөөр өвчлөгсөд 32 болж өмнөх оны мөн үеийнхээс 36 тохиолдол буюу 52.9 хувиар буурсан байна. Нийт халдварт өвчнөөр өвчлөгсдийн 3 буюу 9.4 хувь нь амьсгалын замын халдварт өвчин 24 буюу 75.0 хувь нь бэлэгсийн замын халдварт өвчнөөр өвчилсэн байна.

Зураг I.4.3



Яллагдагчаар татагдвал зохих этгээд нь тогтоогдоогүй хэрэг 13 бүртгэгдэн өнгөрсөн оны мөн үеэс 20 хэргээр буюу 60.6 хувиар буурсан байна.

Зураг I.5.1



Хэргийн өнгөөр нь авч үзвэл:

- Хүнийг алах гэмт хэрэг 1 бүртгэгдэж 1 хэргээр буюу 100 хувиар
- Хөрөнгө завших гэмт хэрэг 2 бүртгэгдэн 2 хэргээр буюу 100 хувь
- Хулгайлах гэмт хэрэг 2 бүртгэгдэж 1 хэргээр буюу 50 хувиар
- Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг 12 бүртгэгдэж 1 хэргээр буюу 8.3 хувиар өссөн байна.
- Хүний амиа хорлох нөхцөл байдалд хүргэх гэмт хэрэг, залилах гэмт хэрэг, тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал ашиглалтын журам зөрчих гэмт хэрэг тус тус 1 бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад ижил түвшинд
- Хууль бусаар мод бэлтгэх гэмт хэрэг 3 бүртгэгдэн 3 хэргээр буюу 100 хувиар
- Мал хулгайлах гэмт хэрэг 4 бүртгэгдэж 9 хэргээр буюу 69.2 хувиар буурсан байна.



I.5 Гэмт хэрэг


Аймгийн хэмжээнд 28 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеийнхээс 6 хэргээр буюу 17.6 хувиар буурсан байна.

Зураг I.5.3

Гэмт хэргийн улмаас учирсан хохирол

Гэмт хэргийн улмаас нийт иргэд, аж ахуй нэгж байгууллагад 49.8 сая төгрөгний хохирол учирснаас иргэдэд 30.7 сая төгрөгний хохирол учирсан байна. Үүнээс бүртгэлд мөрдөн байцаалтын шатанд 11.9 сая төгрөг буюу 23.9 хувийн хохирлыг нөхөн төлүүлж ажилласан байна.

Зураг I.5.2


**Гэмт хэргийн улмаас учирсан хохирол /сая.төг/**

Гэмт хэргийн улмаас 2 хүн нас барсан ба өнгөрсөн оны мөн үеийнхээс 50 хувиар буурсан байна. Гэмт хэргийн улмаас 14 хүн гэмтсэн нь хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийн улмаас 12, хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг гэмт хэргийн улмаас 2 хүн байгаа нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 4 иргэнээр 28.6 хувиар өссөн байна.

Согтуугаар үйлдэгдсэн гэмт хэрэг 8 бүртгэгдэж 5 хэргээр буюу 62.5 хувиар өссөн.

Нийт 1 хэргийг бүлгээр үйлдсэн нь өнгөрсөн оны мөн үеэс 7 хэргээр буюу 87.5 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

11 гэмт хэрэгт 11 хүн холбогдсон нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 5 хүнээр буюу 45.5 хувиар буурсан байна.

Гэмт хэргийн улмаас гэмтсэн, нас барсан иргэн**I.6 Захиргааны зөрчлийн талаар:**

Нийт 706 зөрчилд 32.9 сая төгрөгийн торгуулийн арга хэмжээ авсан байна. Гудамж талбайд хэвийн бус явж орон гэртээ агсан согтуу тавьсны улмаас 41 хүн эрүүлжүүлэгдсэн нь өмнөх оны мөн үеийнхээс 6 хүнээр буюу 12.8 хувиар буурсан байна. Зөрчлийн улмаас нийт 26 хүнийг баривчилж, согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодож эрхээ хасуулж, торгуулсан 27 иргэн байна.

Бүртгэгдсэн зөрчил

Аймгийн хэмжээнд 706 зөрчил бүртгэгдсэн нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 1108 зөрчил буюу 21.5 хувиар буурсан байна. Нийт бэлэн бусын торгууль 32.9 сая.төгрөг болж өнгөрсөн оны мөн үеэс 30.6 сая төгрөг буюу 48.2 хувиар буурсан байна.

**II. Эдийн засгийн үзүүлэлт****II.1 Аймгийн төсөв**


Аймгийн төсвийн нийт орлого 2021 оны 2-р сарын байдлаар 10.6 тэрбум төгрөг, зарлага 8486.7 сая төгрөг болж, аймгийн төсвийн нийт тэнцэл 2066.2 сая төгрөгний эерэг гарлаа.

Өмнөх оны мөн үетэй харьцуулбал нийт орлого ба тусламжийн дүн 0.4 тэрбум төгрөг буюу 3.8

хувиар , урсгал орлого 0.6 тэрбум төгрөг буюу 16.1 хувиар тус тус өссөн дүнтэй байна.

Нийт орлогоос аймгийн төсвийн орлого 4.3 тэрбум төгрөг буюу 90.8 хувийн, сумдын төсвийн орлого 6.2 тэрбум төгрөг буюу 93.3 хувийн гүйцэтгэлтэй байна. Урсгал орлогын гүйцэтгэл 4.0 тэрбум төгрөг буюу 98.3 хувь байна.


Зураг II.1.1 Аймгийн төсвийн орлого, зарлага, сая.төг



Төсвийн нийт зарлага 8486.7 сая төгрөг буюу 65.9 хувийн гүйцэтгэлтэй байна. Үүнээс бараа, ажил үйлчилгээний зардал 8301.1 сая төгрөг буюу 75.8 хувь байна.

Зураг II.1.2

Аймгийн төсвийн өр, авлага, сүүлийн сараар



Нийт өр 3.4 сая төгрөг байна. Нийт авлага байхгүй байна. БСШУС-ын сайдын багцын байгууллага 0.08 сая, орон нутгийн байгууллага 2.0 сая, Эрүүл мэндийн сайдын багцын байгууллага 1.2 сая төгрөгийн өртэй гарсан байна.




II.2 Үнэ

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2021 оны 02 дугаар сард аймгийн хэмжээнд өмнөх оноос 2.1 хувиар өсөж, өмнөх сараас 0.3 хувиар өссөн байна.

Зураг II.2.1

Хэрэглээний бараа үйлчилгээний үнийн индекс, хувь, 2021 II сар, (өмнөх сар =100%)



II.3 Хөдөө аж ахуйн зарим бүтээгдэхүүний зах зээлийн дундаж үнэ

Мал аж ахуйн бүтээгдэхүүний зах зээлийн үнийн судалгаагаар 2021 оны 2 сарын байдлаар ноолуур 40.0 мянга, адууны шир 8.5 мянга, үхрийн шир 1.8-2.3 м шир 4.4 мянга байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулвал адууны шир 14.7 хувиар, үхрийн шир 1.8-2.3 м шир 21 хувиар тус тус өссөн байна.

II.4 Малын дундаж үнэ

Малын дундаж үнэ: 2021 оны 2 сарын байдлаар тэмээ 1300.0 мян.төг, адуу 1000.0 мян.төг, үхэр 1200.0 мян.төг, хонь 160.0 мян.төг, ямаа 135.0 мян.төг болсон байна.

Өмнөх сарын мэдээтэй харьцуулвал адуу 0.3 хувиар өссөн бол үхэр 0.7 хувиар, хонь 1.5, эр ямаа 3.3 хувиар буурсан үзүүлэлттэй байна.




II.5 Аж үйлдвэр

Аймгийн аж үйлдвэрийн газрууд 1349.9 сая төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, 1722.9 сая төгрөгийн бүтээгдэхүүний борлуулалт нийсэн нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад үйлдвэрлэлт 5.6 хувиар өсч, борлуулалт 2.7 хувиар буурсан байна. Боловсруулах аж үйлдвэрийн салбарын борлуулалт 15.1 хувиар буурсан байна.

Зураг II.5.1

Аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэлт, борлуулалт /сая.төг/



II.6 Хөдөө аж ахуй Зүй бусын хорогдол

Том малын зүй бусын хорогдол 2021 оны 2 сарын байдлаар 2810 тоо.толгой болж, өмнөх оны мөн үеийнхээс 2165 тоо.толгой мал буюу 43.5 хувиар буурсан байна. Нийт хорогдлыг малын төрлөөр авч үзвэл адуу 245 тоо.толгой буюу 0.09 хувь, үхэр 268 тоо.толгой буюу 0.11 хувь, хонь 1241 тоо.толгой буюу 0.07 хувь, ямаа 1056 тоо.толгой буюу 0.1 хувь оны эхний малаас тус тус хорогдоод байна. Нийт хорогдлын адуу 8.7 хувь, үхэр 9.5 хувь, ямаа 37.6 хувь, хонь 44.2 хувийг тус тус эзэлж байна. Хорогдлыг сумаар авч үзвэл Могод сум 26.5 хувийг, Дашинчилэн сум 19.5 хувийг тус тус эзэлж байгаа нь дийлэнх болж байна.

Зураг II.6.1


Зүй бусаар хорогдсон том мал, сумаар



Хүснэгт 11.1 Хүн ам, өрх

Сум	Хүн ам				2020 2019	Эрэгтэй				2020 2019	Эмэгтэй				2020 2019
	2017	2018	2019	2020		2017	2018	2019	2020		2017	2018	2019	2020	
Баян-Агт	3218	3251	3273	3304	100.9	1632	1647	1651	1662	100.7	1586	1604	1622	1642	101.2
Баяннуур	1861	1827	1764	1808	102.5	998	977	928	963	103.8	863	850	836	845	101.1
Бугат	2277	2198	2149	2162	100.6	1208	1157	1128	1141	101.2	1069	1041	1021	1021	100.0
Булган	12616	12582	12484	12581	100.8	6125	6160	6085	6136	100.8	6491	6422	6399	6445	100.7
Бүрэгхангай	2888	2872	2822	2824	100.1	1482	1473	1456	1460	100.3	1406	1399	1366	1364	99.9
Гурванбулаг	3219	3289	3289	3278	99.7	1660	1688	1678	1674	99.8	1559	1601	1611	1604	99.6
Дашинчилэн	3037	3008	3084	3042	98.6	1540	1526	1560	1533	98.3	1497	1482	1524	1509	99.0
Могод	2729	2711	2677	2660	99.4	1394	1393	1378	1371	99.5	1335	1318	1299	1289	99.2
Орхон	3595	3477	3587	3603	100.4	1913	1862	1978	1983	100.3	1682	1615	1609	1620	100.7
Рашаант	3215	3253	3235	3222	99.6	1618	1646	1621	1621	100.0	1597	1607	1614	1601	99.2
Сайхан	3662	3561	3556	3590	101.0	1871	1804	1804	1805	100.1	1791	1757	1752	1785	101.9
Сэлэнгэ	3332	3343	3244	3278	101.0	1733	1745	1720	1743	101.3	1599	1598	1524	1535	100.7
Тэшиг	3563	3560	3592	3627	101.0	1820	1809	1835	1849	100.8	1743	1751	1757	1778	101.2
Хангал	4705	4660	4509	4490	99.6	2343	2333	2222	2232	100.5	2362	2327	2287	2258	98.7
Хишиг-Өндөр	3158	3152	3031	3003	99.1	1592	1582	1524	1519	99.7	1566	1570	1507	1484	98.5
Хутаг-Өндөр	4952	5050	5048	5044	99.9	2546	2583	2578	2578	100.0	2406	2467	2470	2466	99.8
Нийт хүн ам	62027	61794	61344	61516	100.3	31475	31385	31146	31270	100.4	30552	30409	30198	30246	100.2


Зураг 1. Хүн амын нас хүйсийн суварга 2020 он






II.7 2021 оны 3 дүгээр сарын цаг агаарын урьдчилсан мэдээ


Бус нутаг	I-р 10 хоног			II-р 10 хоног			III-р 10 хоног			
	Эхэн	Дунд	Эцэс	Эхэн	Дунд	Эцэс	Эхэн	Дунд	Эцэс	
Агаарын температур: Сарын дундаж нь нийт нутгаар олон жилийн дунджийн орчим байж төлөгтэй байна.										
Ихэнх нутгаар	Шөнө: -15.20 Өдөр: +1.4	Шөнө: -10.15 Өдөр: 0+5	Шөнө: -23.28 Өдөр: -9.14	Шөнө: -8.13 Өдөр: +1+6	Шөнө: -21.26 Өдөр: -2.7	Шөнө: -17.22 Өдөр: 0.5	Шөнө: -20.25 Өдөр: -3.8	Шөнө: -12.17 Өдөр: +4+9		
Хур тунадас: Нийт нутгаар олон жилийн дунджийн орчим орох төлөгтэй байна.										
Хур тунадас	Цас оролгүй	Ихэнх нутгаар хур тунадас орох төлөгтэй.	Цас оролгүй	Ихэнх нутгаар хур тунадас орох төлөгтэй.	Цас оролгүй	Ихэнх нутгаар хур тунадас орох төлөгтэй.	Цас оролгүй	Ихэнх нутгаар хур тунадас орох төлөгтэй.	Цас оролгүй	Ихэнх нутгаар хур тунадас орох төлөгтэй.
Салхи: Ихэнх хугацаанд 4-9 м/с, хоёрдугаар арван хоногийн эхэн болон дунд үеэр зарим газраар 15-18 м/с, зарим үед түр зуур 20 м/с хүртэл ширүүсч, цасан болон шороон шуурга шурах төлөгтэй байна.										



Хур тунадас



Агаарын температур



I.1 ХӨДӨЛМӨР

Хүснэгт I.1.1 Хөдөлмөр

Мэдээллийн эх үүсвэр: Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар

Үзүүлэлт	2020 II		2021 II		2021 II % 2020 II	
	Бүгд	эмэгтэй	Бүгд	эмэгтэй	Бүгд	эмэгтэй
Ажил хайгч иргэн /сарын эцэст/	1641	759	711	296	43.3	39.0
Бүртгэлтэй ажилгүй иргэн /сарын эцэст/	1067	520	433	185	40.6	35.6
Ажилд зуучилсан иргэн /эдийн засгийн салбараар/	22	13	18	9	81.8	69.2
ХАА, ойн аж ахуй, загас барилт, ан, агнуур			2			
Боловсруулах үйлдвэр	1					
Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа, холбоо мэдээлэл	3	1				
Төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгаалал	7	4	7	4	100.0	100.0
Боловсрол	2	2			0.0	0.0
Хүний эрүүл мэнд ба нийгмийн халамжийн үйл ажиллагаа	1	1	1	1	100.0	100.0
Бусад	8	5	8	4	100.0	80.0
Ажил хайгч иргэн (насны бүлгээр)	1641	759	711	296	43.3	39.0
15-24	190	84	106	38	55.8	45.2
25-34	584	285	207	93	35.4	32.6
35-44	419	197	200	85	47.7	43.1
45-54	347	162	156	66	45.0	40.7
55-59	78	24	34	12	43.6	50.0
60+	23	7	8	2	34.8	28.6
Хөгжлийн бэрхшээлтэй иргэд			13	4		
Ажил хайгч иргэн (боловсролын түвшнээр)	1641	759	711	296	43.3	39.0
Магистр, доктор	5	3	1	1	20.0	33.3
Дипломын болон бакалаврын дээд	271	175	98	50	36.2	28.6
Тусгай мэргэжлийн дунд	55	31	46	18	83.6	58.1
Техникийн болон мэргэжлийн	72	30	22	3	30.6	10.0
Бүрэн дунд	965	430	451	191	46.7	44.4
Суурь	206	73	62	24	30.1	32.9
Бага	47	11	23	5	48.9	45.5
Боловсролгүй	19	6	8	4	42.1	66.7

I.2 НИЙГМИЙН ХАЛАМЖ

Хүснэгт I.2.1 Нийгмийн халамжийн зарлага, хамрагдсан хүн

Үзүүлэлт	Хүний тоо		Олгосон тэтгэвэр, тэтгэмж, мян. төг		2021 II 2020 II
	2020 II	2021 II	2020 II	2021 II	
Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	7372	7256	688,535.4	982,240.1	142.7
Халамжийн тэтгэвэр	1036	1037	364,683.0	586,841.6	160.9
Нөхцөлт мөнгөн тэтгэмж	1557	1440	236,744.9	260,063.3	109.8
Үүнээс:					
Жирэмсэн болон нярай, хөхүүл хүүхэдтэй эхчүүдийн	240	0	18,005.2	-	-
Ахмад настныг асарч буй иргэний	826	924	129,732.8	160,099.1	123.4
Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг	298	321	46,354.5	53,322.4	115.0
Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг	172	177	39,366.4	43,599.8	110.8
Бүтэн өнчин хүүхэд үрчлэн өсгөний	21	18	3,286.0	3,042.0	92.6
Нийгмийн халамжийн үйлчилгээ болон хөнгөлөлт	309	234	26,731.5	25,383.2	95.0
Ахмад настнуудад үзүүлсэн хөнгөлөлт тусламж	231	189	18,557.5	19,780.0	106.6
Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үзүүлсэн хөнгөлөлт, тусламж	78	40	8,174.0	4,203.2	51.4
Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ	0	5.0	-	1,400.0	-
Хүнс тэжээл хөтөлбөр	4470	4545	60,376.0	109,952.0	182.1
Төрийн өмнөөс гүйцэтгэсэн ажил үйлчилгээ	-	-	-	-	-

Хүснэгт I.2.2 Нийгмийн даатгалын сангийн орлого, зарлага

Үзүүлэлтүүд	2017 II	2018 II	2019 II	2020 II	2021 II	2021 II 2020 II
Нийгмийн даатгалын сангийн орлого, сая.төг	1740.3	1457.6	1680.4	2298.4	6967.5	303.1
Үүнээс:						
Тэтгэврийн даатгалын сан	1044.9	1203.6	1451.4	1898.8	6556.8	345.3
Тэтгэмжийн даатгалын сан	141.4	141	145.2	197.6	217.9	110.3
Эрүүл мэндийн даатгалын сан	430.5					
ҮОМШӨ*-ний даатгалын сан	90.6	79.4	44.3	160.1	95.6	59.7
Ажилгүйдлийн даатгалын сан	32.9	33.6	39.5	41.9	97.2	232.0
Нийгмийн даатгалын сангийн зарлага, сая.төг	5453.7	5609.8	6805	7353.3	8588.3	116.8
Үүнээс:						
Тэтгэврийн даатгалын сан	4840.9	5319.8	6509.6	7023.8	8183.4	116.5
Тэтгэмжийн даатгалын сан	155.0	179.0	206.3	230.0	226.1	98.3
Эрүүл мэндийн даатгалын сан	338.9					
ҮОМШӨ*-ний даатгалын сан	56.4	54.5	43.9	48.8	53.6	109.8
Ажилгүйдлийн даатгалын сан	62.5	56.5	45.2	50.7	125.2	246.9

Хүснэгт I.2.3 Нийгмийн даатгалын сангийн зарлага, хүнээр

Үзүүлэлтүүд	Хүний тоо		Нийгмийн даатгалын сангийн зарлага сая.төг		2021 I-II 2020 I-II
	2020 I-II	2021 I-II	2020 I-II	2021 I-II	
Тэтгэврийн даатгалын сан	9600	10812	1898.8	6556.8	345.3
Тэтгэмжийн даатгалын сан	180	274	197.6	217.9	110.3
ҮОМШӨ*-ний даатгалын сан	52	46	160.1	95.6	59.7
Ажилгүйдлийн даатгалын сан	26	42	41.9	97.2	232.0
Нийт дүн	9858	11174	2298.4	6967.5	303.1

I.3 ЭРҮҮЛ МЭНД

Хүснэгт I.3.1 Аймгийн нэгдсэн эмнэлэгт төрсөн хүүхэд, нас баралт, төрлөөр, оноор

Үзүүлэлт	2018 II	2019 II	2020 II	2021 II	2021/ 2020
Амаржсан эхийн тоо	146	120	119	163	137. 0
Амьд төрсөн хүүхэд	148	124	121	164	135. 5
Эхийн эндэгдэл	-	-	-	-	-
Амьгүй төрөлт	-	-	-	-	-
Гэрийн төрөлт	1.0	-	-	-	-
Нэг хүртэл насандаа эндсэн хүүхэд	4.0	6	2	-	-
Перинаталь эндэгдэл	4.0	5	2	1.0	-
Амьд төрсөн 1000 хүүхэд тутмаас 1 хүртэл насанд эндсэн хүүхэд	27.0	48.4	-	-	-

Хүснэгт I.3.2 Аймгийн хэмжээнд гарсан халдварт өвчин, өвчний төрлөөр, оноор

Үзүүлэлт	2018 II	2019 II	2020 II	2021 II	2021/2020
Нийт гарсан халдварт өвчин	60	79	118	51	43.2
Гэдэсний халдварт өвчин	2	5	4	1	25.0
Амьсгалын замын халдварт өвчин	25	31	45	6	13.3
Байгалын голомтот халдварт өвчин	1	1	-	-	-
Бэлэгсийн замаар дамжих халдварт өвчин	25	35	59	37	62.7
Арьсны халдварт өвчин	7	7	10	7	70.0

I.4 ГЭМТ ХЭРЭГ

Хүснэгт I.4.1 Бүртгээгдсэн гэмт хэрэг, сумдаар

Сум	2017 I-II	2018 I-II	2019 I-II	2020 I-II	2021 I-II	$\frac{2020 \text{ I-II}}{2019 \text{ I-II}} \%$
Булган	17	16	21	17	9	52.9
Баян-Агт	1	2	6	6	2	33.3
Баяннуур	2	2	7	1		0.0
Бугат	4	6	3	16	2	12.5
Бүрэгхангай	3	1	5	9	8	88.9
Гурванбулаг	4	3	1	1	3	300.0
Дашинчилэн	1			4		0.0
Могод	1	2		0	1	0.0
Орхон	4	6	24	9	7	77.8
Рашаант	2	1	8	4	1	25.0
Сайхан	2	2	1	2	1	50.0
Сэлэнгэ	5	3	3	10	3	30.0
Тэшиг	1	2	1	1		0.0
Хангал	2	2		4	5	0.0
Хишиг-Өндөр	6		8	4	4	100.0
Хутаг-Өндөр	2	2	5	4	12	300.0
Хялганат	2	1	1	4	4	100.0
Бүгд	59	51	94	96	62	64.6

Хүснэгт I.4.2 Хулгайн гэмт хэрэг, сумдаар

Сум	2017 I-II	2018 I-II	2019 I-II	2020 I-II	2021 I-II	
Булган		6	8	3	3	2
Баян-Агт			1	4	2	1
Баяннуур		2		3		
Бугат		2		1	2	1
Бүрэгхангай		1			5	2
Гурванбулаг		2		3		
Дашинчилэн					4	
Могод		1	1			
Орхон		2	2	22	6	1
Рашаант		1		2	1	1
Сайхан		2	1	1	2	
Сэлэнгэ		1			6	
Тэшиг			1			
Хангал					1	
Хишиг-Өндөр		2		2	1	
Хутаг-Өндөр		1		2		2
Хялганат					2	1
Бүгд		23	14	43	35	11

Хүснэгт 1.4.3 Гэмт хэргийн улмаас учирсан хохирол

Үзүүлэлт	2017 I-II	2018 I-II	2019 I-II	2020 I-II	2021 I-II
	сая.төгрөг				
Учирсан хохирол-Бүгд	144.8	128.4	200.3	354.3	70.6
Үүнээс:					
Нөхөн төлүүлсэн	84.6	76.7	20.7	25.1	75.9
Нөхөн төлүүлэлтийн хувь	58.4	59.7	10.3	7.1	107.5

Хүснэгт 1.4.4 Сумдын хэргийн илрүүлэлт

Сум	Бүртгэгдэх үедээ сэжигтэн этгээд нь тогтоогдоогүй хэрэг		Яллагдагчаар татаж ял сонгосон хэрэг		Хэргийн илрүүлэлтийн хувь	
